

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- ✓ төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- ✓ зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- ✓ зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх бичиг баримт:

- ✓ Хүсэлт;
- ✓ Төрийн албан хаагчийн анкет;
- ✓ Иргэний үнэмлэхний хуулбар;
- ✓ Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг / диплом/ хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- ✓ Нийгмийн даатгалын дэвтэр, /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, шимтгэл төлсөн цахим лавлагаа;
- ✓ Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- ✓ Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангарагийн хуудас” хуулбар;
- ✓ Мэргэшүүлэх сургалтад хамрагдсны гэрчлэх баримт бичиг;
- ✓ Иргэний, Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт; /e-mongolia–с татан авах/
- ✓ Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- ✓ Цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэний хувьд цэргийн үүрэгтний үнэмлэх;

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 17:30 цаг хүртэл
- Материал хүлээн авах хаяг: Зам, тээврийн хөгжлийн яамны 307 тоот өрөө

ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСААЛТ

№	Албан тушаал	Ангилал	Тавигдах шаардлага			
			Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
Гурав. Бодлого, төлөвлөлтийн газар Мэдээллийн технологийн хэлтэс						
1	Нэгдсэн бодлого, төлөвлөлт, төлөвлөгөө хариуцсан ахлах мэргэжилтэн	T3-7	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	<p>Менежмент ба удирдахуй (041301, 041306-041308);</p> <p>Эдийн засаг (0311);</p> <p>Авто замын инженерчлэл (073210);</p> <p>Гүүрийн инженерчлэл (073205);</p> <p>Барилга замын машин (073211);</p> <p>Тээвэр (1041);</p> <p>Хөдөлгүүрт тээврийн хэрэгсэл, хөлөг онгоц, нисэх онгоц (0716);</p> <p>Эрх зүй (042101);</p>	-	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно
2	Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	T3-7	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	Мэдээлэл харилцаа холбооны технологи (061);	Төрийн албаны зохих мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх.	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.
Дөрөв:Төрийн захиргааны удирдлагын газар Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс						
3	Худалдан авах ажиллагаа, авто замын сангийн санхүүжилт хариуцсан мэргэжилтэн	T3-7	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	<p>Эдийн засаг (0311);</p> <p>Санхүү (041201);</p> <p>Эрхзүй зүй (0421);</p> <p>Бизнесийн удирдлага (041301);</p>	-	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.

Тав: Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газар

4	Төмөр замын боомт, дотоод үйл ажиллагаа хариуцсан ахлах зохион байгуулагч	ТЗ-8	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	Төмөр замын тээврийн удирдлага, зохион байгуулалт (104105); Төмөр замын барилга, зам замын аж ахуй (104106); Логистик менежмент (041308);	-	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.
---	---	------	---	---	---	---

---000---